

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн голын сав газрын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/130/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Хэрлэнбаяр Утас: 89051308 Цахим хаяг: kherlenbayarn@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 389

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн голын сав газрын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн голын сав газрын захиргааны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь тайлант онд улсын төсвөөс 350,061.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 312,129.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 37,931.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 43,128.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж 37,289.8 мянган төгрөгийг зарцуулж 5,838.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 2,104.9 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд 977.9 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1,127.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож хүргүүллээ.

Жолоочийн тооцооны хуудас, шатахуун зарцуулалтын тайлангийн тооцоо бодолт, томилолтын зардал олголтод тавих дотоод хяналт хангалтгүй байгааг анхаарах шаардлагатай.

Бусад асуудлын хэсэг

Байгууллага 2025 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө 8 зорилтын хүрээнд 32 арга хэмжээ тусгаж, 86.1 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж. ГАНБААТАР

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,450,530.00</u>	<u>2,112,408.00</u>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	-
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
33	АВЛАГА	2,845,530.00	663,408.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,845,530.00	663,408.00
35	БАРАА МАТЕРИАЛ	605,000.00	1,449,000.00
354	Хангамжийн материал	605,000.00	1,449,000.00
35410	Бичиг хэргийн материал	319,000.00	627,000.00
35420	Аж ахуйн материал	-	86,000.00
35470	Бусад хангамжийн материал	286,000.00	736,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>255,908,954.59</u>	<u>217,570,124.96</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	255,908,954.59	217,570,124.96
392	Биет хөрөнгө	254,641,021.26	216,555,778.27
39203	Авто-тээврийн хэрэгсэл	310,337,496.50	310,337,496.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	(66,157,082.76)	(117,879,998.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	17,709,800.00	32,958,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,431,546.63)	(11,109,224.63)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,261,670.84	11,760,480.84
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,079,316.69)	(9,511,075.76)
393	Биет бус хөрөнгө	1,267,933.33	1,014,346.69
39303	Бусад биет бус хөрөнгө	1,267,933.33	1,267,933.33
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(253,586.64)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>259,359,484.59</u>	<u>219,682,532.96</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,953,277.25</u>	<u>1,350,663.32</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,953,277.25	1,350,663.32
413	Өглөг	2,953,277.25	1,350,663.32
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,953,277.25	199,763.32
4136	Бусад өглөг	-	1,150,900.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,150,900.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>256,406,207.34</u>	<u>218,331,869.64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	256,406,207.34	218,331,869.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	249,766,207.34	211,691,869.64
51210	Өмнөх үеийн үр дүн	249,766,207.34	249,690,197.35
51220	Тайлант үеийн үр дүн	-	(37,998,327.71)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,640,000.00	6,640,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>259,359,484.59</u>	<u>219,682,532.96</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	494,029,833.33	412,462,599.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,267,933.33	19,273,110.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,267,933.33	19,273,110.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,267,933.33	19,273,110.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,267,933.33	19,273,110.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	492,761,900.00	393,189,489.96
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	454,087,400.00	350,061,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	454,087,400.00	350,061,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	38,674,500.00	43,128,389.96
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,352,100.00	43,128,389.96
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	543,907,962.95	450,460,927.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	543,907,962.95	450,460,927.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	478,695,937.56	406,690,574.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,832,932.89	261,015,892.30
210101	Үндсэн цалин	119,541,073.78	134,400,824.46
210102	Нэмэгдэл	52,224,914.86	79,639,676.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,173,500.00	23,343,000.00
210104	Урамшуулал	15,893,444.25	23,632,391.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,966,621.97	32,607,817.78
210201	Тэтгэврийн даатгал	17,742,712.40	22,379,914.43
210202	Тэтгэмжийн даатгал	2,022,410.46	2,559,953.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	962,312.57	1,227,486.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,060,097.89	1,227,486.18
210205	Эрүүл мэндийн даатгал	4,179,088.65	5,212,977.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	14,850.00
210303	Цэвэр, бохир ус	-	14,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	40,941,410.00	20,900,370.00
210401	Бичиг хэрэг	2,633,600.00	2,754,200.00
210402	Тээвэр, шатахуун	1,059,110.00	14,949,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	928,950.00	849,475.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21,115,750.00	2,347,275.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,322,450.00	8,860,000.00
210604	Урсгал засвар	12,511,850.00	8,860,000.00
2107	Томилолт, зочны зардал	26,578,000.00	24,120,000.00
210702	Дотоод албан томилолт	26,578,000.00	24,120,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,841,017.00	955,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	258,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	742,017.00	191,770.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	195,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	109,000.00	450,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,263,505.70	58,215,944.39
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	53,100.00	130,004.76
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,210,405.70	58,085,939.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,212,025.39	43,770,353.20
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,477,725.39	43,770,353.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,477,725.39	37,931,783.24
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,838,569.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(49,878,129.62)	(37,998,327.71)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(49,878,129.62)	(37,998,327.71)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>492,761,900.00</u>	<u>393,189,489.96</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>492,761,900.00</u>	<u>393,189,489.96</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	<u>454,087,400.00</u>	<u>350,061,100.00</u>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	454,087,400.00	350,061,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	<u>38,674,500.00</u>	<u>43,128,389.96</u>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,322,400.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,352,100.00	43,128,389.96
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>492,761,900.00</u>	<u>392,629,489.96</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>492,761,900.00</u>	<u>392,629,489.96</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>426,997,284.61</u>	<u>348,859,136.76</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	<u>209,702,568.82</u>	<u>261,583,298.98</u>
210101	Үндсэн цалин	119,410,709.71	134,400,824.46
210102	Нэмэгдэл	52,224,914.86	79,639,676.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,173,500.00	23,343,000.00
210104	Урамшуулал	15,893,444.25	24,199,797.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	<u>25,989,238.79</u>	<u>32,607,817.78</u>
210201	Тэтгэврийн даатгал	17,765,329.22	22,379,914.43
210202	Тэтгэмжийн даатгал	2,022,410.46	2,559,953.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	962,312.57	1,227,486.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,060,097.89	1,227,486.18
210205	Эрүүл мэндийн даатгал	4,179,088.65	5,212,977.45
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	<u>14,850.00</u>
210303	Цэвэр, бохир ус	-	14,850.00
2104	Хангамж, бараа материалын зардал	<u>33,507,960.00</u>	<u>20,507,470.00</u>
210401	Бичиг хэрэг	4,742,900.00	2,046,775.00
210402	Тээвэр, шатахуун	16,059,110.00	14,949,420.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	861,850.00	782,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	204,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,640,100.00	2,729,175.00
2105	Нормативт зардал	<u>800,000.00</u>	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	<u>24,350,000.00</u>	<u>6,810,000.00</u>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,750,000.00	450,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	800,000.00	-
210604	Урсгал засвар	17,800,000.00	6,360,000.00
2107	Томилолт, зочны зардал	<u>26,760,500.00</u>	<u>24,120,000.00</u>
210702	Дотоод албан томилолт	26,760,500.00	24,120,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,834,917.00	505,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,395,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	258,930.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	742,017.00	191,770.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	195,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	102,900.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52,100.00	2,710,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	52,100.00	210,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	65,764,615.39	43,770,353.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,734,300.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,280,000.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	28,454,300.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	28,030,315.39	43,770,353.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,477,725.39	37,931,783.24
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	552,590.00	5,838,569.96
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	≡	<u>560,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	560,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	560,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	560,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	560,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	≡	<u>(560,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	6,640,000.00	249,766,207.34		256,406,207.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	6,640,000.00	249,766,207.34	-	256,406,207.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(12,698,388.48)		(12,698,388.48)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	6,640,000.00	249,766,207.34	-	256,406,207.34
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	6,640,000.00	249,766,207.34	-	256,406,207.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(76,009.99)		(76,009.99)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	6,640,000.00	249,690,197.35	-	256,330,197.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(37,998,327.71)		(37,998,327.71)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	6,640,000.00	211,691,869.64	-	218,331,869.64

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү дүн
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	355,598,100.00	312,129,316.76	43,468,783.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	355,598,100.00	312,129,316.76	43,468,783.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,598,100.00	312,129,316.76	43,468,783.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,719,400.00	261,583,298.98	35,136,101.02
210101	Үндсэн цалин	135,061,400.00	134,400,824.46	660,575.54
210102	Нэмэгдэл	113,929,800.00	79,639,676.83	34,290,123.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,942,200.00	23,343,000.00	1,599,200.00
210104	Урамшуулал	22,786,000.00	24,199,797.69	(1,413,797.69)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,488,800.00	32,607,817.78	1,880,982.22
210201	Тэтгэврийн даатгал	23,451,600.00	22,379,914.43	1,071,685.57
210202	Тэтгэмжийн даатгал	2,759,200.00	2,559,953.55	199,246.45
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,379,700.00	1,227,486.17	152,213.83
210204	Ажилгүйдлийн даатгал	1,379,700.00	1,227,486.18	152,213.82
210205	Эрүүл мэндийн даатгал	5,518,600.00	5,212,977.45	305,622.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	928,500.00	14,850.00	913,650.00
210301	Гэрэл, цахилгаан	349,500.00	-	349,500.00
210302	Түлш, халаалт	417,600.00	-	417,600.00
210303	Цэвэр, бохир ус	161,400.00	14,850.00	146,550.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,746,200.00	7,337,650.00	2,408,550.00
210401	Бичиг хэрэг	2,020,400.00	1,686,375.00	334,025.00
210402	Тээвэр, шатахуун	2,149,000.00	2,140,000.00	9,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,016,100.00	782,100.00	234,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	537,500.00	-	537,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,023,200.00	2,729,175.00	1,294,025.00
2105	Нормативт зардал	716,700.00	-	716,700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	716,700.00	-	716,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,794,500.00	7,370,000.00	1,424,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,010,000.00	1,010,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,424,500.00	-	1,424,500.00
210604	Урсгал засвар	6,360,000.00	6,360,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	-	500,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	-	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	994,000.00	505,700.00	488,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	560,200.00	258,930.00	301,270.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	317,100.00	191,770.00	125,330.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	116,700.00	55,000.00	61,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,710,000.00	2,710,000.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	2,500,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,000.00	210,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	355,598,100.00	312,129,316.76	43,468,783.24
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	355,598,100.00	312,129,316.76	43,468,783.24
131001	Улсын төсвөөс санхүүжих	355,598,100.00	312,129,316.76	43,468,783.24
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих			-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	43,128,389.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,128,389.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,289,820.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,169,820.00
210401	Бичиг хэрэг	360,400.00
210402	Тээвэр, шатахуун	12,809,420.00
2107	Томилолт, зочны зардал	24,120,000.00
210702	Дотоод албан томилолт	24,120,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,838,569.96
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,838,569.96
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,838,569.96
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	43,128,389.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	43,128,389.96
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	43,128,389.96
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын явцад 977.9 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Тавилга, эд хогшил дансанд 828.9 мянган төгрөгийн, машин тоног төхөөрөмж дансанд 72.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсоныг нөхөж тооцон элэгдлийг зардлыг нэмэгдүүлж залруулсан.
- Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчийн цалинг цалингийн нэгдсэн системд бүрэн татуулаагүйн улмаас 76.0 мянган төгрөгийн авлагын зөрүү үүсэж тайланг зөрүүтэй илэрхийлснийг өмнөх үеийн үр дүн дансанд хааж залруулсан.

Аудитаар нийт 1,127.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 төлбөрийн акт тогтоож хүргүүлэв.

3.1 Төлбөрийн акт

Өмнөх тайлант хугацаанд үүссэн 1,127.1 мянган төгрөгийн татварын авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.2 Албан шаардлага

Байхгүй.

3.3 Зөвлөмж

Байхгүй.

*Нийт илрүүлсэн 1,127.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулагдаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан	1	901.9	1	901.9			1	901.9				
Санхүүгийн тайланд авлага зөрүүтэй бүртгэсэн	1	76.0	1	76.0			1	76.0				
Дүн	2	977.9	2	977.9	0	0	2	977.9	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй	1	1,127.1	1	1,127.1								
Дүн	1	1,127.1	1	1,127.1								

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн												
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн												

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 49-А2371281

Чингис хот

ХЭА-2026/130/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн голын сав газрын захиргааны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх тайланд хугацаанд үүссэн татварын авлагын үлдэгдэл 1,127,052.70 (нэг сая нэг зуун хорин долоон мянга тавин хоёр төгрөг далан мөнгө) төгрөгийг барагдуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн." гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Авлагын үлдэгдэл 1,127,052.70 (нэг сая нэг зуун хорин долоон мянга тавин хоёр төгрөг далан мөнгө) төгрөгийг дарга Б.Нандинцэцэгээр төлүүлж аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг дарга Б.Нандинцэцэгт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Н. Хэрлэнбаяр



Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР